



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 35

Номгон

**Эрдэмтэн Я.Дашжамцын судалгааны тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д **ДААЛГАХ** нь:

1.1. Хүрээмарал сумын Улсын тусгай хамгаалалттай нөөц газар нутагт Төв Азийн байгалийн ургамлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах Биологийн ухааны доктор, профессор Я.Дашжамцын саналыг судалж танилцуулсугай.

1.2. “Ахуйн хэрэглээний байгалийн ургамлыг нөхөн сэргээх арга ухаан” хэмээх 5 боть ном хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсүгэй.

1.3. Мөнх ногоон гацуур нарс, самарын хуш 5000 ширхэгийг үржүүлэх техник эдийн засгийн үндэслэл, судалгаа шинжилгээг хийлгэж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлсүгэй.

3. Ахуйн хэрэглээний байгалийн ургамлыг нөхөн сэргээх арга номын ургамал тарималжуулах, нутагшуулах аргачлалын талаар иргэдэд сургалт явуулах талаар харьяа хэлтэс, агентлагуудтай хамтран ажилласугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР